

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2025 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ**

2025 оны 09 дүгээр сарын 22

Багануур дүүрэг

№	ХБТББ-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц	Хувь
								Зорилтод түвшин үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ- ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ												
Зорилт 4.3. Эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, бүтээлч эдийн засгийг хөгжүүлнэ.												
Зорилго: 4.3.3. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлэн, дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлсэн байна.												
7	Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барьж, үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлнэ.	Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110кВ-ын 6.76 км өндөр хүчдэлийн агаарын шугамын бүтээн байгуулалтын ажлыг дуусгах	2021-2025	БҮТП ХК	Нийслэлийн төсөв	2,174.1	5	100	2,174.1	2,174.1	2022-2024 онд Нийслэлийн төсвөөс нийт 1,874.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 110кВ-ийн 6.76 км урт ЦДАШ-ын бүх суурийн ажил хийгдэж, эхний анкер тулгууруудыг босгож дууссан. 2025 онд бүтээн байгуулалтын үлдэгдэл 300.0 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 13-ний өдрийн А/197 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар (НХОГ)-т шилжүүлсэн. НХОГ-ын 2025 оны А/21 дугаар тушаалын дагуу 2025.03.14-ний өдөр Паркийн үндсэн ерөнхий цахилгаан хангамжийн 110кВ-ын 6.76км цахилгаан дамжуулах агаарын шугамыг Эрчим хүчний барилга байгууламжаар бүртгэн ашиглалтад оруулахаар дараах	100

										байгууллагуудын төлөөллийг оролцуулсан техникийн комисс ажилласан. - Захиалагч: НХОГ ОНӨААТҮГ - Зургийн автор: Мон-Энержи Консалт ХХК - Гүйцэтгэгч: Энх өглөө ХХК - Өмчлөгч: Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК - Ашиглагч: БҮТП ХК - Месес ХХК Техникийн комисс нь улсын комисс ажиллуулахаар шийдвэрлэж дараах бэлтгэл ажлуудыг хангуулсан. 220/110/35кВ-ын Багануур дэд станцын өргөтгөл, гаргалгаа, релэй хамгаалалт, удирдлагын панель, угсралтын ажил - Шилжүүлэг ажлын хүрээнд таслалт хийх хүсэлтийг ашиглагч байгууллагад хүргүүлэх - Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн зөвлөмжийн дагуу зарим шаардлагатай тоноглолыг захиалан угсрах Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2025 оны 08 дугаар сарын 29-ний А/206 дугаар тушаалын дагуу Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын цахилгааны хэлтсийн дарга Д.Батзоригоор ахлуулсан Улсын комисс 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр ажиллаж	
--	--	--	--	--	--	--	--	--	--	---	--

											шугамыг ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэсэн.	
											Хэрэгжилт	100



ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *[Signature]* Б.БЯМБАЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА *[Signature]* Б.МИЧИД-ЭРДЭНЭ

БОДЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА *[Signature]* Б.МӨНГӨНХУЯГ